

С. Ишдорж

**МАХН-ЫН XVII ИХ ХУРЛААС ДЭВШҮҮЛСЭН  
ГАДААД БОДЛОГЫН ЧИГ ШУГАМ ХЭРЭГЖИЖ  
БАЙГАА НЬ**

Манай оронд социализмын материал-техникийн бааз байгуулж дуусгахын чухал алхам-БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх VI таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг баталсан МАХН-ын XVII их хурал манай гадаад бодлогын гол зорилтыг ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой амьдралын бүх хүрээнд улам ойртон нягтрах, бодит социализмын байр суурийг дэлхий дахинд бэхжүүлэх, империализм, дайнч харгис хүчний түрэмгий явууллагын эсрэг тэмцэх, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энэ тайвнаар зэрэгцэн орших зарчмыг хэрэгжүүлэх, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, капиталист орнуудын ажилчин ангийн хувьсгалт тэмтлийг дэмжих, орчин үеийн хувьсгалт бүх хүчнийг нягтруулах, дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулах явдал мөн гэж тодорхойлон заасан билээ.

МАХН-ын XVII их хурал монгол-зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, нягт хамтын ажиллагаа чанарын шинэ шатанд орсныг тэмдэглээд, БНМАУ-аас социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны өмнө ЗХУ-тай бүх талаар ойртон нягтрах нь манай орны хөгжлийн бодит зүй тогтол мөн<sup>1</sup> гэсэн гүн гүнзгий дүгнэлт хийсэн юм.

Намын XVII их хурлаас хойш өнгөрсөн хугацаанд БНМАУ-аас, ЗХУ социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой амьдралын бүх салбарт ойртон нягтрахад манай улс болон эдгээр орны хоорондын улам өргөжин хөгжиж байгаа улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагаа онцгой чухал үүрэг гүйцэтгэж байна.

БНМАУ-аас ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой улс төр, эдийн засгийн болон бусад талаар ойртон нягтрахад МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал тэргүүтэй манай нам-засгийн төлөөлөгчид 1976 оны 10-р сард ЗХУ-д, 1977 оны 5-р сард БНАГУ-д, 1978 оны 5-р сард БНСЧСУ-д албан ёсны нөхөрсөг айлчлалт хийж, хамтарсан албан мэдэгдэл гарган БНМАУ, БНАГУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулж, ЗХУ ба БНСЧСУ тай эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн болон бусад хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх баримт бичигт гарын үсэг зурсан явдал чухал хувь нэмэр болов. Мөн өнгөрсөн оны намар ВКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНСВУ-ын Үндэсний Хурлын Байнгын хорооны дарга нөхөр Чыонг Тинь тэргүүтэй БНСВУ-ын Үндэсний Хурлын төлөөлөгчид, ВКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНБАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Станко Тодоров, энэ оны 9-р сард Унгарын Ажилчны Социалист Намын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНУАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нөхөр Дьердь

Лазар тус тус манай оронд нөхөрсөгөөр айлчилж, хамтарсан мэдэгдэл гаргасан нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай манай найрамдал, хамтын ажиллагаа улам гүнзгийрэн бэхжиж байгаагийн тод илрэл юм.

Ах дүү социалист орнуудын улс төрийн хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд тэдгээр орны коммунист, ажилчны намуудын хоорондын нягт хэлхээ холбоо, нам, төрийн удирдагчдын уулзалтууд чухал үүрэг гүйцэтгэж байна.

МАХН-ын төлөөлөгчид, ВКН-ын IV их хурал, ЮКН-ын XI их хуралд оролцсон хийгээд социалист хамтын нөхөрлөлийн орнуудын коммунист, ажилчны намтай намын ажилтны болон бусад төлөөлөгчид, мөн хэвлэл, мэдээлэл солилцож байгаа нь МАХН ба эдгээр орны намын хоорондын хэлхээ холбоог өргөтгөн зузаатгах, социалист, коммунист байгуулалтын хаа туршлагатай харилцан танилцахад чухал ач холбогдолтой зүйл мөн.

Сүүлийн жилүүдэд ах дүү социалист орнуудын коммунист, ажилчны намын удирдагчдын уулзалт Крымд болж, тэдгээр орны намын төв хороон!» намын зохион байгуулалт, үзэл суртлын ажил эрхэлсэн нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөн тогтмол хийгдэж, мөн төр, олон нийтийн байгууллагын шугамаар хэлхээ холбоо, хамтын ажиллагаа өргөжиж ирсэн нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг улс төрийн талаар улам ойртуулан нягтруулах, тэдгээрээс социалист, коммунист байгуулалтын асуудлыг амжилттай шийдвэрлэх, энх тайван, олон улсын аюулгүй байдлын төлөө тэмцлийн бодлогоо нийцүүлэн зохицуулах чухал ач холбогдол бүхий үйл явдал болов.

Социалист хамтын нөхөрлөлийн орнудаас нийгэм-эдийн засгийн бодлогоо амжилттай хэрэгжүүлэх, социалист эдийн засгийн интеграцын цогцолбор программыг биелүүлэх, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн болон бусад хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх, тэдгээрийг эдийн засгийн талаар ойртуулан нягтруулах үйлсэд гол чухал үүргийг ЭЗХТЗ ийн хүрээнд манай орнуудын хооронд буй хоёр ба олон талын хамтын ажиллагаа гүйцэтгэж байгаа юм.

Социалист эдийн засгийн интеграцын хүрээнд манай улс ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой хоёр ба олон талын хамтын ажиллагаагаа цуцалтгүй өргөтгөн хөгжүүлж байна.

Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, аз жаргалтай амьдрал, хөгжил цэцэглэлтийн найдвартай баталгаа болсон монгол-Зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, бүх талын хамтын ажиллагаа улам бэхжин өргөжиж, ЗХУ-аас манай орны үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, хөдөлмөрчдийн материаллаг аж байдал, соёлын түвшинг дээшлүүлэхэд үзүүлж байгаа чин сэтгэлийн тусламж улам өсөн нэмэгдэж байна. Үүний тод нотолгоо бол энэ таван жилд ЗХУ-аас манай улсад үзүүлж буй тусламж түрүүчийн хоёр таван жилд үзүүлсэн тусламжийн нийт хэмжээнээс илүү гарч байгаа явдал юм.

ЗХУ-ын тусламжтайгаар тус орны улс ардын аж ахуй, соёлын янз бүрийн салбарт 240 гаруй томоохон барилга байгууламж баригдаж байгаагийн дотор монгол, зөвлөлтийн барилгачдын хамтын хүчээр сүндэрлэн босч байгаа Эрдэнэтийн зэс, молибдены том үйлдвэрийн цогцолбор орж байгаа юм. Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, Нягт хамтын ажиллагааны улам өсөн нэмэгдэж байгаа цар хэмжээ, ажлын явцыг ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нөхөр Л.И.Брежнев үнэлж хэлэхдээ: «...Одоо Эрдэнэтэд зэс, молибдены аврага том үйлдвэр барьж байгуулахад Дархан хотод таван жилийн дотор гарсантай тэнцэх хөрөнгийг ганцхан жилд зарж байна. Зөвхөн энэ баримтаас үзэхэд Монгол

Ард Улсын өсөн нэмэгдсэн бүтээн байгуулах бололцоо, бидний хамтарсан ажлын шинэ далайц, үнэн хэрэгтээ зөвлөлт-монголын хамтын ажиллагааны чанарын шинэ түвшин толинд туссан юм шиг харагдаж байна»<sup>2</sup> гэсэн билээ.

Эрдэнэтийн зэс молибдены том үйлдвэрийн цогцолборын бүрэлдэхүүнд багтаж буй Салхит-Эрдэнэтийн төмөр зам, Орхон-Эрдэнэт, Эрдэнэт-Сэлэнгийн өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугам, Дархан-Эрдэнэтийн сайжруулсан авто зам болон олон мянган хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууц, сургууль, соёл, ахуйн үйлчилгээний олон барилга байгууламж ашиглалтанд орж, Эрдэнэтийн уул уурхайн баяжуулах комбинатын эхний ээлж удахгүй ашиглалтанд орох гэж байна. Үүний зэрэгцээ ЗХУ-ын тусламжтайгаар Багануурын нүүрсний орд газрыг эзэмших барилга байгууламж барих ажил амжилттай хийгдэн, түүний хэсэг болох Бага хангай-Бага нуурын төмөр замын ажиллагаа эхэлсэн, түүнчлэн ЗХУ-ын тусламжаар аж үйлдвэр, хөдөө аж ахуй, сургууль, соёл, эрүүлийг хамгаалах болон нийгэм-ахуйн үйлчилгээний олон тооны барилга байгууламж баригдаж ашиглалтанд ороод байна.

Монгол, Зөвлөлтийн эдийн засаг, соёлын харилцаа нь хоёр орны улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх хэтийн болон жилийн төлөвлөгөөг харилцан зохицуулах, хоёр орны яам, тусгай газруудын хооронд, мөн ЗСБНХУ-ын зарим муж, хязгаар, автономит бүгд найрамдах улс, БНМАУ-ын аймаг, хотуудын хооронд шууд харилцааг тогтоон хөгжүүлэх зэрэг хэлбэрээр улам өргөжин баяжиж байна.

Манай орны социалист бүтээн байгуулалтанд ЗХУ-аас гадна БНБАУ, БНАГУ, БНМАУ, БНСРУ, БНУАУ, БНСЧСУ аж үйлдвэр, хөдөө аж ахуй, нийгэм-ахуйн үйлчилгээ, соёлын газрыг барих, боловсон хүчин бэлтгэх замаар туслалцаа үзүүлж байна.

Энэ оны намар Улаанбаатар хотноо хуралдсан ЭЗХТЗ-ийн гүйцэтгэх хорооны 87-р чуулганаар БНМАУ-ын эдийн засгийн хөгжилтийг түргэтгэх, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн цогцолбор программы тусгай арга хэмжээг биелүүлэхтэй холбогдсон асуудал, ЭЗХТЗ-ийн чуулганы ХХХII хуралдааны шийдвэрийн биелэлтийн явц болон энэ талаархи цаашдын зорилтын тухай, Тавантолгойн коксжсон нүүрсний орд газрыг ашиглахад хамтран ажиллах тухай асуудлыг авч хэлэлцэн, хамтын ажиллагааны урт хугацааны зорилтот программуудын тэргүүн ээлжийн чухал арга хэмжээг хэрэгжүүлэх алхмыг сайшааж, манай орны социалист бүтээн байгуулалтад хойшид ч бүх талын тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд илэрхийлжээ. Тус хуралдаан дээр нөхөр Ю. Цэдэнбал хэлсэн үгэндээ ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хоёр ба олон талын үндсэн дээр улам бүр бэхжүүлж байгаа хамтын ажиллагаа нь БНМАУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах хүчирхэг хүчин зүйл болж, ЗХУ, социалист хамтын нөхөрллийн бусад орон монголын ард түмний цаашдын цэцэглэлт, сайн сайхан байдлын талаар жинхэнэ интернационалч халамж тавин, манай орны социалист бүтээн байгуулалтад бүх талаар тусалж байгааг онцлон тэмдэглээд, «ЗХУ болон ах дүү социалист бусад оронтой интеграцын хэлхээ холбоогоо бүх талаар хөгжүүлэх чиг бодлого нь манай нам, БНМАУ-ын засгийн газрын гадаад бодлогын хувиршгүй үндэс мөн бөгөөд монголын ард түмний үндсэн эрх ашиг, нийт социалист хамтын нөхөрлөлийн эрх ашигт бүрэн нийцэж байна»<sup>3</sup> гэсэн билээ.

2 Л. И. Брежнев хэлсэн үг., «Үнэн», 1976 оны 10-р сарын 19.

3 ЭЗХТЗ-ийн Гүйцэтгэх Хорооны 87-р хуралдаан дээр нөхөр Ю. Цэдэнбалын хэлсэн үг.

«Үнэн», 1978 оны 9-р сарын 28.

ЭЗХТЗ-ийн хүрээнд БНМАУ ба социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хоорондын шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна.

1977 оны 2-р сард Москва хотноо болсон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчдийн зөвлөлгөөн ах дүү социалист орнуудын коммунист, ажилчны намуудын их хурлуудын шийдвэрээр шинжлэх ухааны өмнө дэвшүүлэн тавьсан зорилтуудын дагуу шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр ашгийг дээшлүүлэх, социалист орнуудын эрдэмтдийн хамтын ажиллагааг цаашид улам өргөтгөн хөгжүүлэх, байгалийн ба нийгмийн ухааны гол гол асуудлуудыг хамтран шийдвэрлэх, шинжлэх ухааны ололт амжилтыг улс ардын аж ахуйд улам гүнзгий нэвтрүүлэх, шинжлэх ухааны дээд ололтыг хөдөлмөрчдийн эрх ашиг, нийгмийн дэвшил, энх тайвны зорилгод чиглүүлэх зэрэг цаг үеийн өргөн хүрээтэй асуудлыг уг зөвлөлгөөнөөр хэлэлцсэн явдал ах дүү орнуудын шинжлэх ухааны байгууллагуудын хоёр ба олон талын улам бүр өргөжин хөгжиж буй хамтын ажиллагаа, шинжлэх ухааны интеграцыг илтгэн харуулсан чухал үйл явдал болов.

БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи, түүний Дорнодахины судлалын хүрээлэн өөрийн үйл ажиллагаанд МАХН-ын XVII их хурлын шийдвэрийг удирдлага болгон, ах дүү социалист орнуудын шинжлэх ухааны байгууллагуудын хоёр ба олон талын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Монголын ард түмэн ЗХУ болон ах дүү социалист бусад оронтой ойртон нягтарч байгаагаараа эх орныхоо социалист бүтээн байгуулалтыг улам түргэтгэн дэлхийн социализмын хүчийг бэхжүүлж байгаа юм. Манай оронд МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНАЛАУ-ын ерөнхий сайд нөхөр Кейсон Фомвихан тэргүүтэй лаосын нам-засгийн төлөөлөгчдийн айлчлах үеэр гаргасан «Монгол-Лаосын хамтарсан тунхаглалд» энэ тухай дурдахдаа: «Монголд социализмыг байгуулж байгаа болон БНМАУ-ын нэр хүнд олон улсын тавцан дээр өсөн нэмэгдэж байгаа нь социализмын хүчийг бэхжүүлэх үйл хэрэгт чухал хувь нэмэр болж, энх тайван, үндэсний тусгаар тогтнол, ардчилал, социализмын төлөө тэмцэж байгаа улс түмний тэмцлийг зоригжуулж байна гэж Лаосын тал үзэж байна»<sup>4</sup> гэсэн юм.

МАХН-ын тууштай баримталсаар ирсэн гадаад бодлогын чиг шугамын дагуу манай улс үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, хөрөнгөтөн орнуудын ажилчин ангийн хувьсгалт тэмцлийг дэмжин, нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орон энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг хэрэгжүүлж, империализм, дайнч харгис хүчний эсрэг Ази болон дэлхий дахины энх тайван, улс түмний аюулгүй байдлыг хангахын төлөө шийдвэртэй тэмцэж байна.

БНМАУ капитализмыг алгасан феодализмаас социализмд шилжин орох марксист-ленинист сургаалыг бодит зүйл болгосон орны хувьд ч, социалист хамтын нөхөрлөлийн эрх тэгш гишүүний хувьд ч дэлхийн социализмын зүй ёсны холбоотон-үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг зүйл бүрээр дэмжиж байдаг билээ.

МАХН-ын XVII их хурлаас хойш манай улс эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, Ази, Африк, Латин Америкийн орнуудын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг урьдын адил тууштай дэмжиж, империализм, колоницлол, соинизм, арьсны үзэлтнүүд, дайнч харгис хүчний эсрэг үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшил хөгжил, энх тайвны төлөө шинэ тулгар

4 Монгол-Лаосын хамтарсан Тунхаглал, «Үнэн», 1976 оны 10-р сарын 14.

улсуудын ард түмний явуулж буй тэмцэлтэй эв санааны нэгдлээ илэрхийлэн, бололцоотой бүхнийг хийж байна. Үүнийг энэ оны хавар Бүгд Найрамдах Мозамбик Ард Улсын нам-засгийн төлөөлөгчид манай оронд айлчлах үеэр гаргасан монгол-мозамбикийн албан мэдээ болон хамтарсан Тунхаглалд орсон зүйлээс тодорхой харж болно.

Уг албан мэдээ, тунхаглалд хоёр улсын хооронд эв найрамдлын хэлхээ холбоо, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт хойшид ч бэхжүүлэн гүнзгийрүүлж, хоёр орны нам, төрийн болон олон нийтийн байгууллагын хэлхээ холбоог бэхжүүлэн хөгжүүлэх, туршлага солилцох явдлыг бүхий л аргаар дэмжинэ гэдгээ хоёр тал илэрхийлсэн байна. Мөн хоёр тал Африкийн байдлыг хэлэлцээд, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Родезийн арьсны үзэлт дэглэмийн явуулж байгаа арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бодлого болон апартейд бодлогын системийг шийдвэртэй эсэргүүцэн, дээрх дэглэмээс Африкийн тусгаар тогтносон улс орны эсрэг түрэмгий явууллага үйлдсээр байгааг эрс буруушааж, өөртөө засан тохинож, үндэснийхээ тусгаар тогтнолыг хангахын төлөө Зимбабве, Намибийн ард түмний явуулж байгаа шударга тэмцлийг бүрэн дэмжиж, эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлжээ.

Империализм болон бусад харгис хүчин Африкийн зарим орны харгис бүлэг, дэглэмтэй сүлбэлдэж, Африкт түрэмгий явууллага идэвхжүүлж байгаа нөхцөлд колоничлол, шинэ колоничлол, арьсны үзлийн бүх хэлбэр, илэрлийг устгахын төлөө тэмцэлд Африк тивийн дэвшилт бүх хүчний эв санааны нэгдлийг бэхжүүлэх, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, чөлөөлөгдсөн орнуудаас дэлхийн социализмын орнууд болон бусад дэвшилт бүх хүчинтэй тогтоосон холбоог улам зузаатгах явдал чухал ач холбогдолтой болохыг хоёр тал тэмдэглэсэн байна.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих талаар хоёр тал санал нэгтэй байгаагаа илэрхийлэн, Монгол-Мозамбикийн хамтарсан тунхаглалд: «империалист харгис хүчний өнгөлзлөгөөс үндэснийхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэхийн төлөө чөлөөлөгдсөн улс орнуудаас явуулж байгаа тэмцэлд хоёр тал цаашид ч зүйл бүрийн дэмжлэг үзүүлэх болно»<sup>5</sup> гэж дурджээ.

МАХН, БНМАУ, монголын ард түмэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжихийн зэрэгцээ хөрөнгөтөн орнуудын ажилчин ангийн хувьсгалт тэмцэл, түүний манлай отряд-коммунист, ажилчны намуудын үйл ажиллагаатай эв санааны нэгдлээ бэхжүүлж байна. Үүнийг Германы Коммунист намын дарга Герберт Мис дагалдсан нөхдийнхөө хамт, Израилийн Коммунист Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Мейер Вильнер тэргүүтэй ИКН-ын төлөөлөгчид, Австрийн Коммунист Намын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Эрвин Шарф зэрэг хүмүүс манай оронд айлчилж, хамтарсан албан мэдээ гаргасан явдал тод харуулж байна.

Дэлхийн социализмын орнууд, олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний отрядуудын эв нэгдлийг бэхжүүлэх, орчин үеийн хувьсгалт бүх хүчнийг нягтруулахад аугаа их Октябрийн социалист хувьсгалын 60 жилийн ойн баяр ёслолыг бүх дэвшилт хүн төрөлхтөн өргөн тэмдэглэсэн явдал чухал ач холбогдолтой болов. Уг баяр ёслолд нөхөр Ю. Цэдэнбал тэргүүтэй манай нам-засгийн төлөөлөгчид оролцож, Октябрийн 60 жилийн ойд зориулан манай оронд болон ах дүү социалист орнууд, коммунист, ажилчны намууд, мөн тэдний төв хэвлэл «Энх тайван, социализмын асуудал» сэтгүүлийн газарт марксист-ленинист онол, практикийн эрдэм шинжилгээний семинар, зөвлөлгөөн, бага хур-

лууд зохиогдсон зэрэг нь хувьсгалт хөдөлгөөний отрядуудад тэмцэл, үйл ажиллагааныхаа туршлагыг солилцож харилцан мэдэх өргөн бололцоо олгожээ.

БНМАУ гадаад бодлогын үйл ажиллагаандаа социалист хамтын нөхөрлөлийн орнуудын гадаад бодолгын нэгдмэл чиг шугам болон ЗХУКН ын XXV их хурлаас дэвшүүлсэн энх тайвны төлөө цаашдын тэмцлийн программыг бүрэн дэмжиж МАХН-ын XVII их хурлын заалтыг удирдлага болгон, нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орон энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг хэрэгжүүлэх, харилцан ашигтай эрх тэгш хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын аюулгүй байдал, Ази болон дэлхий дахинд өнө удаан бат бэх энх тайвныг сахин бататгахын төлөө цуцалтгүй тэмцэж байна.

Манай улс ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны нэг адил ангич, интернационалч гадаад бодлого явуулан, дэлхийн халуун цөмийн дайны аюулыг сэрэмжлэх, дайныг нийгмийн амьдралаас тонилгох, энх тайван, аюулгүй байдлын нөхцөлд хүн төрөлхтний нийгмийн дэвшлийг хангахыг эрмэлздэг юм.

Энх тайванч гадаад бодлогынхоо үндсэн зорилго, тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийн тулд МАХН, БНМАУ-ын засгийн газар бүх нийтийн энх тайван, олон улсын аюулгүй байдал, хүн төрөлхтний нийгмийн дэвшлийн төлөө империализм, дайнч харгис хүчинтэй хийж байгаа тэмцэлдээ социалист хамтын нөхөрлөлийг бэхжүүлэх, орчин үеийн хувьсгалт гол гурван хүч-дэлхийн социализм, хөгжингүй хөрөнгөтөн орнуудын ажилчны хөдөлгөөн, улс түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн холбоог бататгах, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших, харилцан ашигтай эрх тэгш хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, олон улсын намжмал байдлын үйл явцыг гүнзгийрүүлэх, даян дэлхийн энх тайвныг эрхэмлэгч бүх хүчнийг нэгтгэх талаар ЗХУ-ын Коммунист Нам, Зөвлөлт засгийн газар, биечлэн нөхөр Л. И. Брежнев-ын гаргаж байгаа их чармайлыг гуйвалтгүй дэмжиж байна.

ЗХУ болон ах дүү социалист бусад орон, түүний дотор манай улсын гаргаж байгаа тууштай чармайлт, тодорхой зорилго бүхий социалист гадаад бодлогын ачаар намжмал байдлыг гүнзгийрүүлэх үйл явц дэлхий дахины өнөөгийн хөгжлийн зонхилох хандлага болж, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчим орчин үеийн олон улсын харилцааны нийтээр зөвшөөрөн хүлээж байгаа хэм хэмжээ болон хувирч байна.

БНМАУ МАХН-ын XVI их хурлаас хойш шинээр 10 шахам оронтой дипломат харилцаа тогтоосноор одоо нийтдээ дэлхийн 85 оронтой дипломат харилцаатай болж, 30 шахам оронтой худалдаа хийж байна.

Түүнчлэн манай орон олон улсын 60 гаруй байгууллагын гишүүнээр ажиллаж, тэдгээрт оролцдог манай төлөөлөгчид энх тайван, улс түмний оюулгүй байдал, хамтын ажиллагаа, нийгмийн дэвшлийн үйлсийг тууштай дэмжиж байна.

Бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, намжмал байдлын үйл явцыг гүнзгийрүүлэх, Ойрхи дорнод болон Африк тив дэх дайны голомтыг арилгах, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хязгаарлан зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, хүмүүсийг үй олноор устгадаг цөмийн зэвсэг болон шинэ төрлийн зэвсэг, тухайлбал нейтроны бөмбөг үйлдвэрлэх явдлыг хориглохын төлөө тэмцэх, олон улсын харилцаанд хүч хэрэглэхгүй байх, улсуудын хоорондын эрх тэгш байдал, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө улс түмний тэмцлийг дэмжих зэрэг хүн төрөлхтний

чухал асуудлыг НҮБ болон олон улсын бусад байгууллагад нааштай шийдвэрлүүлэх талаар манай улс социалист хамтын нөхөрлөлийн орнууд болон энхийг эрхэмлэгч хүчний хамт чармайн ажиллаж байна.

Манай улсын төлөөлөгчид НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXI -- XXXIII чуулганууд болон зэвсэг хураах асуудлаар хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганы ажиллагаанд идэвхтэй оролцож, БНМАУ 1969 оноос эхлэн зэвсэг хураах хорооны гишүүнээр, 1912 оноос зэвсэг хураах асуудлаар дэлхий дахины бага хурлыг зарлан хуралдуулах тусгай хорооны гишүүнээр ажиллаж, түүний ажлыг тодорхой үр дүнд хүргэхийн төлөө ах дүү нөхдийн хамт цуцалтгүй тэмцэж байна. Мөн манай улс байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэрэг-дайны зорилгоор ашиглахыг хориглосон НҮБ-ын 1977 оны конвенцид нэгдэн орж, НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудтай үр бүтээлтэй хамтын ажиллагааг хөгжүүлэн, НҮБ-ыг энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах байгууллагын хувьд нь улам бэхжүүлэхийн төлөө гуйвалтгүй тэмцэж байна.

НҮБ дахь БНМАУ-ын идэвхтэй үйл ажиллагааг өнгөрсөн оны намар манай оронд зочилсон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Курт Вальдхайм үнэлж хэлэхдээ: «Монгол улс 1961 оноос НҮБ-ын дүрэмд заасан энх тайвны найрсаг харилцаа, олон улсын хамтын ажиллагааны дээд зарчмуудыг дэмждэг идэвхтэй гишүүний нэг болсон билээ...

Монгол улс хамтын ажиллагааны үзэл санаагаар НҮБ-д хандаж, дэлхийн энх тайвныг бэхжүүлэхэд чиглэсэн санаачлагуудыг дэмжиж байдгийг бид сайн мэддэг юм»<sup>6</sup> гэжээ.

Азийн социалист орон-БНМАУ энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр нийгмийн янз бүрийн байгуулалтай улс орон харилцан итгэлцэж нөхөрсөгөөр хамтран ажиллах бололцоо байгааг харуулсан нийт Европын Хельсинкийн зөвлөлгөөний төгсгөлийн баримт бичгийн үзэл санааг дэлхийн бөмбөрцгийн бусад нутаг район, тухайлбал өргөн уудам Ази тивд дэлгэрүүлэх, энэ тивийн жинхэнэ аюулгүй байдлыг цэрэг, зэвсгийн хойноос хөөцөлдөж, цэргийн эвсэл бүлэглэл байгуулахад биш, харин улсуудын хоорондын харилцаанд хүч хэрэглэхээс татгалзах, тэдгээрийн бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, ард түмэн бүр хувь заяагаа өөрсдөө шийдэх эрхийг хүндэтгэх, байгалийн баялгаа өөрсдөө эзэмших, нийгэм-эдийн засгийн үндсэн өөрчлөлт хийх ард түмний хөдлөшгүй эрхийг хангах, олон улсын маргаантай асуудлыг улс төрийн аргаар, хэлэлцээний замаар шийдвэрлэх, олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ нарийн чанд сахин биелүүлэх, эдийн засгийн болон бусад хэлбэрийн хамтын ажиллагааг эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр хөгжүүлэх замаар Азид бат бэх энх тайван тогтоохын төлөө өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж байна.

Энэ эрхэм зорилгоор манай Гадаад Явдлын яамны төлөөлөгчид Ази, Африкийн нилээд орноор айлчилсанаас гадна БНАЛАУ, БНЭУ-ын парламентын төлөөлөгчид, мөн Энэтхэгийн Гадаад Явдлын яамны сайд БНМАУ-д зочилжээ.

Монгол, Энэтхэгийн Гадаад явдлын яамны сайд нарын хамтран гаргасан мэдэгдэлд улс орныхоо өмнө тулгарч байгаа нийгэм-эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн Энэтхэгийн засгийн газар, ард түмний хүчин чармайлтыг Монголын засгийн газар, ард түмэн талархан дэмжиж байдгийг БНМАУ-ын Гадаад Явдлын яамны сайд илэрхийлээд, эвсэлд үл нэгдэх, улс гүрнүүд энх тайвнаар зэрэгцэн орших зарчимд тулгуурласан Энэтхэг улсын энх тайванч гадаад бологыг БНМАУ-ын засгийн га-

зар өндрөөр үнэлж байдгийг мэдэгдсэн байна. Энэтхэгийн Гадаад Явдлын Яамны сайд монголын ард түмнээс нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх, Ази болон дэлхий дахины энх тайван, улс түмний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн БНМАУ-ын гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд олж байгаа амжилтыг БНЭУ-ын засгийн газар өндрөөр үнэлж байдгийг илэрхийлжээ.

Хоёр сайд Азийн байдлыг онцгой анхааран, энх тайван, тогтвортой байдлыг хамтын хүчин чармайлтаар бэхжүүлэх, Хельсинкийн үзэл санааг тус тивд дэлгэрүүлэх, Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгохын төлөө, колоничлол, шинэ колоничлолын бодлогын эсрэг нийтийн тэмцэлд, мөн бүх улс түмний тусгаар тогтнол, эрх чөлөөг хамгаалах, үндэсний бүрэн эрхт байдал, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг хүндэтгэх үндсэн дээр улс гүрний хоорондын харилцааг тогтоох хэрэгт эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нааштай хувь нэмэр оруулж байна<sup>7</sup> гэж санал нэгтэй мэдэгджээ.

Манай улс 1976 оны 8-р сард Ши Ланка улсын нийслэл Коломбо хотноо болсон эвсэлд нэгдээгүй улсуудын төр, засгийн газрын тэргүүн нарын бага хурлаас Хельсинкийн үзэл санааг Ази тивд дэлгэрүүлэх талаар гаргасан чухал шийдвэрийг сайшаан дэмжсэнээс гадна эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг хөгжүүлэн бэхжүүлэхийн төлөө тэмцсээр байна.

Өнөө үеийн дэлхий дахины байдлын гол хандлага болсон намжмал байдлын үйл явцыг гүнзгийрүүлэн бэхжүүлэхийн эсрэг Ази болон дэлхийн бусад районд олон улсын байдлыг хүндрүүлэх гэж империализм, харгис хүчин, бээжингийн маоист удирдагчид элдвээр оролдож байна.

Хятадын удирдлага их гүрний дээрэнгүй жанжлах эрмэлзлэлээ хэрэгжүүлэхийн тулд улс орноо цэрэгжүүлж, БНХАУ-ын төсвийн бараг тэн хагасыг цэргийн зардалд зориулан, пуужин, цөмийн зэвсгийн хойноос улайран хөөцөлдөж, Октябрийн хувьсгал, ленинизмийн эх орон-ЗСБНХУ-ыг өөрийнхөө 1-р зэргийн дайсан гэж илт зарлан «умардын аюул» гэгч зохиомол зүйл гаргаад, ЗХУ, манай БНМАУ болон социалист хамтын нөхөрлөл, тэдгээрийн энх тайванч гадаад бодлогыг нүд үзүүлэн харааж, империалист хамгийн харгис дайнч хүчинтэй эвсэлдэж Ази ба дэлхий дахины энх тайван, улс түмний аюулгүй байдалд нэн осолтой бодлого явуулж байна. Энэ оны намар Хятад, Японы хооронд байгуулсан «энх тайван, найрамдлын тухай» гэрээ гэгчид гурав дахь гүрний «жанжлалыг» эсэргүүцэх зүйл оруулсан нь бээжингийн удирдагчид ЗХУ-ын болон социализмын эсрэг тэмцэлдээ Японыг татан оруулж, японы улам бүр толгойгоо өндийлгөж байгаа дайнч харгис хүчнийг өөгшүүлэн, Ази ба дэлхий дахины энх тайван, аюулгүй байдалд заналхийлсэн маш хорон санаа бүхий хуйвалдаан юм. Саяхан БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Дэн Сяопин Японд очиж, цэрэгжүүлэлтээ улам хүчтэй болгохыг уриалсан үг хэлсэн явдал бээжингийнхэн ЗХУ, социализмын эсрэг дайнд өөрсдөө бэлтгээд зогсохгүй, Японы дахин сэргэж буй милитаризмыг улам турхирч байгааг бас харуулж байна.

Хятадын удирдагчид «Зөвлөлт, Варшавын гэрээний байгууллагын аюул» өсөн нэмэгдэж байгаа мэтээр үздэг хөрөнгөтний суртал нэвтрүүлгийг шүүрэн авч дэвэргэн, АНУ ба НАТО-гийн орнуудыг цэрэг зэвсгээ улам нэмэгдүүлэхийг илэрхий уриалж, өрнөдийн гүрнүүд, Японтой улс төр, цэрэг-эдийн засгийн нягт хэлхээ холбоо тогтоох талаар бүхнийг хийж байна. Тэд дэлхийн дайн «зайлшгүй» гэж Мао Цзэ-дүний хэлсэн зүйлийг дахин давтан ярьж, өөрсдийн түрэмгий явууллагыг элдвээр далд-

7 БНМАУ, БНЭУ-ын Гадаад Явдлын яамны сайд нарын хамтран гаргасан мэдэгдэл, «Үнэн», 1976 оны 9-р сарын 11

лан хаацайлж, дэлхийн социализмын эсрэг «өргөн фронт» байгуулах нь орчин үеийн «нэн чухал зорилт» мэт үздэг боллоо

ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын энх тайванч гадаад бодлогын чиг шугам, үндсэн зарчим манай орнуудын нам, төрийн дээд байгууллагуудын их хурлын шийдвэрт болон намын программ, үндсэн хуульд тодорхой заасан байдаг билээ. Манай орнуудын гадаад бодлогын чиг шугам бол Социализм, коммунизм байгуулахын энх тайван нөхцлийг хангах явдал мөн. Энэ эрхэм дээд зорилгод ЗХУ-аас НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXII чуулганд оруулсан «цөмийн зэвсэггүй улсуудын аюулгүй байдлыг баталгаатай болгох тухай санал», стратегийн зэвсгийг хорогдуулах асуудлаар гэрээ байгуулах тухай Зөвлөлт-Америкийн хооронд нааштай явагдаж буй хэлэлцээ, мөн саяхан Францад ЗСБНХУ-ын Гадаад Явдлын яамны сайд нөхөр А.А.Громыко-гийн хийсэн айлчлал зэрэг гадаад бодлогын чухал алхамууд бүрэн дүүрэн нийцэж байна.

Харин Хуа Го-фэн тэргүүтэй хятадын одоогийн удирдагчдын гадаад бодлого нь Мао Цзэ-Дүний гадаад бодлогын чиг шугамыг ямар ч өөрчлөлтгүйгээр үлдээж, түүний хамгийн харгис, их гүрний дээрэнгүй жанжлах зорилтыг олон улсын тавцан дээр хэрэгжүүлэхэд бүрмөсөн чиглэжээ. Тэд балмад бодлогоо хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө айл зэргэлдээ орнуудынхаа газар нутагт өнгөлзөн, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцохыг оролдох, элдэв дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, өөрсдийн гар хөл болж байгаа этгээдийг турхирч өдөөн хатгалга хийх, тэдгээр орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлэх балмад явууллагыг улам илт хийх боллоо.

Хятадын удирдагчид, Вьетнамд амьдарч буй хятад иргэдийн асуудлыг зориуд өдөн гаргаж, БНСВУ-ын эсрэг Кампучийн дэглэмийг турхиран, зэвсэгт өдөөн хатгалга хийж, Вьетнамын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтносон байдалд шууд заналхийлж байна. Бээжингийн эрх баригчдын адал балмад бодлого нь америкийн империализм, түүний гар хөл бологчдын эсрэг эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан байлдаж түүхэн их ялалт байгуулсан вьетнамын баатарлаг ард түмэн, ВКН, БНСВУ-ын засгийн газрын эрс эсэргүүцэлтэй тулгарч, тухай бүр няцаалт авч байна. Хятадын талын буруугаар вьетнам-хятадын хоорондын маргааныг зохицуулах хэлэлцээ тасарчээ. Одоо бээжингийнхэн БНСВУ-ын эсрэг өдөө хатгалгаа улам хүчтэй болгож байна.

Хятадын эрх баригчид ЗХУ-ын зарим газар нутаг, манай орныг түрэмгийлэн эзэлж Хятадад завсарган нийлүүлэх бодлогоо бас явуулж байгаа юм. Манай улсын эсрэг, олон улсын тавцан дээр хятадын удирдагчдын явуулж буй их гүрний дээрэнгүй жанжлах бодлого, жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэл суртал-харгис маоизмтай эвлэршгүй тэмцэх талаар МАХН-ын XVII их хурлаас хийсэн шинжлэх ухааны үндэстэй гүн гүнзгий дүгнэлт үнэн зөв болохыг амьдрал бүрэн дүүрэн нотоллоо.

Бээжингийнхэн манай улсын эсрэг, манай ах дүүгийн найрамдалт их өмөг түшиг ЗХУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлээ яаравчлан хийж байгаа нь хятадын аюул бодитой болохыг харуулж байна.

Хятадын удирдагчид БНМАУ-ын тусгаар тогтнол, аюулгүй байдалд заналхийлээд зогсоогүй бас манай улсын эсрэг эдийн засаг, үзэл суртлын хорлон сүйтгэх явууллагаа улам хүчтэй болгосоор байгаа юм. Энэ нь хоёр орны худалдаа эрс багассан, манай орныг дайран гардаг олон улсын төмөр замаар галт тэргийг ачаа бараагүй явуулах, Бээжин болон манай улстай хил залгаа Хятадын нутгаас хятад, монгол, казах, орос, англи зэрэг хэл дээр гүтгэлгийн нэвтрүүлэг хийх, Хятадын хэвлэлд Монголын эсрэг, монгол-зөвлөлтийн найрамдлын эсрэг өгүүллүүд нийтлэгдэж байгаа зэргээр тод илэрч байна.

Марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмаас бүрмөсөн урван тэрслэсэн бээжингийн удирдагчид ЗХУ, социалист хамтын нөхөрлөл, олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг эсэргүүцсэн бүх харгис хүчинтэй ойр дотно харилцаа тогтоож, эвсэл холбоо байгуулан, дэлхийн хувьсгалт бүх хүчний эв нэгдлийг эвдэн бусниулахад чиглэсэн балмад явууллага үйлдсээр байна.

Манай улс БНХАУ-тай харилцах, маоизмтай тэмцэхдээ МАХН-ын XVII их хурлаас өгсөн зарчмын заалтын дагуу социалист хамтын нөхөрлөл, Дэлхийн коммунист хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалах, империализмыг эсэргүүцсэн бүх хүчний эгнээг нягтруулах интернационалч эрх ашигт гуйвалтгүй үнэнч байх зарчмыг удирдлага болгон, Хятадтай харилцаагаа хэвийн болгохыг чармайхын зэрэгцээ социализм, коммунизмын эсрэг, Зөвлөлтийн эсрэг үзэл-харгис маоизмтай эвлэршгүй тэмцэл хийсээр байна.

МАХН нь ЗХУКН болон ах дүү коммунист, ажилчны бусад намын нэг адил олон улсын коммунист хөдөлгөөний эв нэгдлийг марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмын үндсэн дээр бэхжүүлэх, империализм, дайнч харгис хүчний эсрэг улс түмний энх тайван, аюулгүй байдал үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө, орчин үеийн хувьсгалт бүх хүчнийг нягтруулахын төлөө тэмцлийн үйлсэд идэвхтэй хувь нэмэр оруулсаар байна.

Эд бүхэн бол энх тайван, ардчилал, үндэсний тусгаар тогтнол, социализмын үйл хэргийн ялалтын тусын тулд МАХН-ын XVII их хурлаас дэвшүүлсэн гадаад бодолгын чиг шугам амжилттай хэрэгжиж байгаагийн бат нотолгоо мөн.

**С. Ишдорж**

## ВНЕШНЕПОЛИТИЧЕСКИЙ КУРС XVII СЪЕЗДА МНРП В ДЕЙСТВИИ

### Резюме

Автор анализирует практические мероприятия партии и правительства МНР по осуществлению внешнеполитического курса, выработанного XVII съездом МНРП.

После XVI съезда МНРП все более расширяется и углубляется всестороннее сотрудничество МНР со странами социалистического содружества, в первую очередь с Советским Союзом. В этом отношении большую роль сыграли такие внешнеполитические шаги МНРП и Правительства МНР, как официальные дружественные визиты партийно-правительственной делегации во главе с Первым Секретарем ЦК МНРП, Председателем Президиума Великого Народного Хурала МНР тов. Ю. Цеденбалом в Советский Союз (октябрь 1976 г.), в ГДР (май 1977 г.), в ЧССР (май 1978 г.) и др.

В ускорений процесса всемерного сближения МНР с Советским Союзом и другими странами мирового социализма, в углублении их политического сотрудничества важное значение имеют состоявшиеся в Крыму встречи партийных руководителей наших стран, регулярные совещания секретарей Центральных комитетов коммунистических и рабочих партий

братских социалистических государств по вопросам партийно-организационной и идеологической работы, а также все развивающиеся связи и тесное сотрудничество по линии государственных и общественных организаций.

Особую роль в успешном осуществлении странами социалистического содружества, в том числе МНР, своей социально-экономической политики. Комплексной программы социалистической экономической интеграции, расширении их экономического сотрудничества, в их экономическом сближении играет двустороннее и многостороннее сотрудничество братских стран социализма в рамках СЭВ. Решение состоявшегося осенью 1978 года в Улан-Баторе 87-го заседания Исполкома СЭВ имеют важное значение для успешного осуществления специальных мероприятий Комплексной Программы, касающихся МНР.

МНР оказывает всевозможную поддержку национально-освободительному движению народов-естественному союзнику мирового социализма.

В статье анализируются важные документы, подписанные МНР с представителями национально-освободительного движения после XVII съезда МНРП.

Наряду с этим, МНРП и монгольский народ, непоколебимо поддерживают революционную борьбу рабочего класса и трудящихся капиталистических стран против засилья монополистического капитала, против сил реакции, империализма и войны, за мир, демократию и социальный прогресс. Важное значение имеет посещение нашей страны Председателем КП Германии Гербертом Мисом. Генеральным Секретарем ЦК Израильской КП Мейером Вильнером, членом Политбюро и Секретарем ЦК КП Австрии Эрвином Шарфом.

МНРП неустанно борется за осуществление принципов мирного сосуществования государств с различными социальными системами, за мир и безопасность народов Азии и всего мира.

МНР вместе со странами социалистического содружества и другими миролюбивыми государствами и силами прилагает активные усилия для того, чтобы в ООН и других международных организациях нашли свое положительное решение такие жизненно-важные для человечества проблемы, как процесс углубления разрядки, устранение военных очагов на Ближнем Востоке и в Африке, ограничение гонки вооружений, разоружение, запрещение производства новых видов оружия массового уничтожения, в частности нейтронных бомб, неприменение силы в международных отношениях, развитие равноправного и взаимовыгодного сотрудничества, поддержка борьбы народов за свободу, национальную независимость и социальный прогресс своих стран и др.

МНР, как азиатская страна, сосредотачивает свое внимание на положительном решении неотложных проблем этого обширного континента, как распространение духа Кельсинки в Азии развитие отношений дружественного сотрудничества между государствами континента на основе общепринятых демократических принципов международных отношений, проведение коренных социально-экономических преобразований, сохранение и упрочение мира и безопасности в Азии.

В статье дается анализ важных внешнеполитических шагов, предпринятых правительством МНР в этом направлении после XVII съезда МНРП, подвергается научнообоснованной критике авантюристическая внешнеполитическая линия пекинского руководства, выражающаяся в усиленной милитаризации страны, в форсированной подготовке к войне против СССР, МНР и других стран мирового социализма, в усилении

сговора с самыми реакционными силами в мире, а также в их попытках аннексировать соседние с Китаем страны.

Развитие событий в Китае за последнее время полностью подтверждает правильность установок XVII съезда МНРП о необходимости вести непримиримую борьбу с реакционным маоизмом, являющимся концентрированным выражением антикоммунизма и антисоветизма, национализма и шовинизма.

МНРП, успешно реализуя решения своего XVI съезда, вносит активный вклад в дело укрепления единства и сплоченности рядов международного коммунистического движения на принципиальной основе марксизма-ленинизма и пролетарского интернационализма, в дело сплочения всех революционных сил современности, в борьбу за мир и безопасность народов, против сил империалистической реакции и военных авантюр.